

БАТЛАВ  
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧ

Я.САРАНСҮХ

**“ҮНДЭСНИЙ МӨНГӨН ТЭМДЭГТ-ТӨГРӨГИЙН БОЛОН ВАЛЮТЫН ХАНШНЫ  
ӨӨРЧЛӨЛТИЙГ ТОГТВОРЖУУЛАХ БОДЛОГЫН ҮР НӨЛӨӨ” АУДИТЫН ХҮРЭЭНД  
ШИНЖИЛГЭЭ ХИЙЖ, ДҮГНЭЛТ ГАРГАХ ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР**

2023 оны 3 дугаар сарын 17-ны өдөр

Дугаар *УАТ-АБ/*  
*2023-21*

Улаанбаатар хот

**Ажлын зорилго:** “Үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн болон валютын ханшны өөрчлөлтийг тогтворжуулах бодлогын үр нөлөө”-нд хийх аудитын хүрээнд Монгол банк, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогод дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулах, аудитын багт мэргэжлийн тусалцаа үзүүлэхэд энэхүү ажлын зорилго оршино.

**Ажил гүйцэтгэх:** 2023.04.03-ны өдрөөс 2023.06.30-ны өдөр хүртэл

**Байршил:** Улаанбаатар хот

### **НЭГ. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.3, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө батлах тухай” А/03 дугаар тушаалыг тус тус үндэслэн “Үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн болон валютын ханшны өөрчлөлтийг тогтворжуулах бодлогын үр нөлөө”-нд хийх аудитын багт зөвлөх үйлчилгээ үзүүлж, ажлын даалгаварт тусгасан ажлыг гүйцэтгэн дүгнэлт гаргана.

### **ХОЁР. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ, ҮҮРЭГ**

Зөвлөх нь аудитын багтай хамтран Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу ажлын даалгаварт заасан ажлыг журам, АДБОУС болон холбогдох бусад баримт бичигт нийцүүлэн чанартай, арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй хэлбэрээр цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх үүрэгтэй.

Ажлын зорилтын хүрээнд Үндэсний аудитын газар, Монголбанк, Сангийн яам, холбогдох байгууллагуудад ажиллана.

Зөвлөх нь дараах ажилбаруудыг гүйцэтгэж, аудитын талбарын болон тайлагналын үе шатанд шаардлагатай мэргэжлийн, нотлох баримтаар баталгаажсан үндэслэлтэй санал, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулна. /Хавсралт/

Гэрээт ажлын тайланд тавигдах шаардлага, хэмжээ, формат,

- Үе шатны ажлын тайлангууд нь хавсралтууд орохгүйгээр 15-аас багагүй, 35-аас ихгүй хуудас /мөр хоорондын зай “single” үсгийн фонт Arial, хэмжээ 12-тай/ байх бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан, хавсралтуудтай байна.
- Дагалдах материал болон үнэлгээний тайлангийн эх бичвэрийн файлыг хавсаргана.
- Үе шатны болон нэгдсэн тайлан боловсруулахад ашигласан хууль тогтоомж, ном, хэвлэл, холбогдох бусад мэдээлэл зэрэг эх үүсвэрийн жагсаалтыг хавсаргана.

## **ГУРАВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ**

Аудитад Монгол Улсад 2020-2022 оны гадаад валютын ханшийн өсөлт, төгрөгийн худалдан авалтын чадамжийн бууралт, түүнд нөлөөлсөн гадаад, дотоод хүчин зүйлсийн судалгаа шинжилгээ, холбогдох бусад баримт материалд үндэслэн Монголбанк, Засгийн газраас хэрэгжүүлсэн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, холбогдох төрийн байгууллагын чиг үүргийн хэрэгжилтийн байдлыг хамруулна.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд,

- Урьдчилсан судалгааны үе шатанд цуглуулсан баримт материалтай танилцах
- Аудитын төлөвлөгөөнд санал өгөх
- Аудитад ашиглах горим сорилуудыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх
- Аудитын асуудлын шинжилгээг боловсруулахад оролцох

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд,

- Аудитын төлөвлөгөөний дагуу горим, сорилыг хэрэгжүүлэх
- Аудитаар илэрсэн асуудлыг илрүүлэлтийн матрицад тусгуулах
- Аудитаар илэрсэн зөрчлийг зөрчлийн бүртгэлд тусгуулах
- Аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулах

Аудитын тайлагналын үе шатанд,

- Шинжээчийн ажлын тайлангийн төслийг боловсруулах
- Шинжээчийн ажлын тайланд үе шатны хяналт хийлгэх
- Шинжээчийн ажлын тайланг эцэслэн баталгаажуулж, нэгдсэн тайланд нэгтгүүлэх

## **ДӨРӨВ. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН**

Аудитын төлөвлөлтийн үе шатанд,

- Шалгагдагч байгууллагын талаарх ойлголт
- Аудитын төлөвлөгөөнд өгсөн санал
- Асуудлын шинжилгээ боловсруулахад өгсөн санал

Аудитын гүйцэтгэлийн үе шатанд,

- Аудитын төлөвлөгөөнд тусгасан горим, сорилыг хэрэгжилт
- Аудитын илрүүлэлт
- Аудитаар илэрсэн зөрчлийг зөрчлийн бүртгэлд тусгасан байдал
- Аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулалт

Аудитын тайлагналын үе шатанд,

- Шинжээч нь ажлын даалгаварт дурдсан ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, ажлын үр дүнг илтгэсэн шинжээчийн тайлан бичнэ.
- Шинжээчийн тайланд судалгааны явцад илэрсэн асуудлууд, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн шинжилгээний үр дүнд дүгнэлт өгч цаашид анхаарах асуудал, авах арга хэмжээний талаар зөвлөмж, саналыг боловсруулж тайланд тусгана.
- Тайлан болон холбогдох судалгаа, тооцооллыг нотлох ажлын баримтыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

## **ТАВ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

Гүйцэтгэх ажил үүргийн хүрээнд ажиллах иргэн, хуулийн этгээд нь /цаашид “шинжээч” гэх/ “Үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн болон валютын ханшны өөрчлөлтийг тогтворжуулах бодлогын үр нөлөө” сэдэвт аудитын ажлыг гүйцэтгэх Үндэсний аудитын газрын аудитын багийн бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллана.



Тус ажлыг ажлын даалгаврын дагуу гүйцэтгэхээр шалгарсан хуулийн этгээд /хувь хүн, баг/ нь захиалагч Үндэсний аудитын газрыг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, аудитын багтай уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно.

Үе шатны ажлын явцад бий болсон шийдвэрлэх боломжгүй асуудлыг тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд даруй мэдэгдэнэ.

## **ЗУРГАА. ТАВИГДАХ ШААРДЛАГА БОЛОН АЖЛЫН ТУРШЛАГА**

Зөвлөх нь тухайн аудитад оролцоход ашиг сонирхлын зөрчилгүй, хувь хүн, байгууллага, албаны болон төрийн нууцыг задруулахгүй гэдгээ бүрэн илэрхийлж, Үндэсний аудитын газартай нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Тавигдах шаардлагын хүрээнд ажиллахад дараах боловсролын үндсэн мэргэжил, зэрэг, мэргэшлийн шаардлага тавигдана. Үүнд:

### **Хуулийн этгээдийн хувьд:**

- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий болохыг нотлох баримт бичиг;  
Хуулийн этгээдийн багийн ахлагч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
- Банк, санхүү, эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн, мэргэжлээрээ 10 ба түүнээс дээш жил ажилласан туршлагатай, дүн шинжилгээ хийх чадвартай байх;
- Банк, санхүү, эдийн засгийн чиглэлийн баримт бичигт судалгаа хийж, холбогдох мэргэжлийн дүгнэлт боловсруулах чадвартай;
- Төрийн болон албаны нууц, байгууллага болон хувь хүний нууцыг чандлан хадгалах;
- Мэргэжлээрээ зөвлөх үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай;
- Хууль тогтоомжид заасан бусад шаардлага

### **Ажиллах хүчний шаардлага:**

- Банк, санхүүгийн чиглэлээр бакалавр түүнээс дээш зэрэгтэй;
- Мэргэжлээрээ 5-аас дээш жил ажилласан;
- Банк, санхүү, эдийн засгийн чиглэлийн баримт бичигт судалгаа хийж, холбогдох мэргэжлийн дүгнэлт боловсруулах чадвартай
- Компьютерын өргөн хэрэглээний болон бусад программ ашиглах чадвартай;
- Төрийн болон албаны нууц, байгууллага болон хувь хүний нууцыг чандлан хадгалах;

### **Баг, хувь хүний хувьд:**

- Шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, боловсролын зэргийн диплом, бусад үнэмлэх, сертификатын хуулбар;
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрх бүхий болохыг нотлох баримт бичиг;
- Ажлын туршлагыг тодорхойлсон дэлгэрэнгүй намтар;
- Техникийн санал (үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө), санхүүгийн дэлгэрэнгүй санал (тусад нь дугтуйлсан байх)

Дээрх ажлын даалгаврын 6-д заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичгийн баталгаажсан хуулбарыг Үндэсний аудитын газрын цахим хаягаар ирүүлнэ үү.

Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гэрээ, ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд гүйцэтгэж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо, тайлан бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

## **ДОЛОО. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ**

Зөвлөхийн ажлын хөлсийг харилцан тохиролцож, төлбөрийн нөхцөлийг ажлын гүйцэтгэлд үндэслэн, гэрээнд заасан нөхцөл, хуваарийн дагуу олгоно.

Монгол Улсын Ерөнхий Аудиторын орлогчийн  
2023 оны 3 дугаар сарын 17-ны УАГ-АД/2023-21  
дугаартай баталсан ажлын даалгаврын  
Хавсралт

| д/д  | Гүйцэтгэх ажил, үүрэг  | Хугацаа                  | Үндэслэл  | Зорилго   | Шалгуур үзүүлэлт  |
|--|--|--------------------------|---|---|---|
| 1  | Хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээний үр дүнд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах   | 2023.04.03<br>2023.05.15 | Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.4, 5.5, 5.6, 5.7 | Монголбанк, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогод дүн шинжилгээ хийх            | -Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/<br>-Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.4, 5.5, 5.6, 5.7<br>-Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор баталж хэрэгжүүлсэн 10 их наяд төгрөгийн хөтөлбөр, түүний үр дүн |
| 2  | Олон улсын валютын сан, бусад банк санхүүгийн байгууллагын зөвлөмжийн дагуу хийсэн ажлын үр дүнд шинжилгээ хийж дүгнэлт гаргах | 2023.04.03<br>2023.05.15 |   | Цаашид үндэсний мөнгөн тэмдэгт-төгрөгийн тогтвортой байдлыг хангахад зөвлөмж өгөх | -Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль<br>-Шатах тослох материал худалдан авахад зарцуулсан валютын хэмжээ   |
| 3  | Валютын ханш тогтворжуулах талаар макро түвшинд хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд шинжилгээ хийж дүгнэлт гаргах                    | 2023.04.03<br>2023.05.15 |   |   | - Олон улсын валютын сан, бусад банк, санхүүгийн байгууллага, хөндлөнгийн шинжээчдийн өгсөн зөвлөмжийн хэрэгжилт  |
| 4  | Гадаад валютын улсын нөөцийг эзэмших, удирдах, валютын ханшийг тогтвортой байлгах үйл ажиллагаанд дүгнэлт гаргах;              | 2023.04.03<br>2023.05.15 |   |   | -Импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн чиглэлээр төрөөс хэрэгжүүлсэн бодлогын үр дүн  |
| 5  | Төлбөрийн тэнцлийн болон урсгал дансны алдагдалд дүгнэлт гаргах  | 2023.04.03<br>2023.05.15 |   |   | - Төсвийн тухай хуулийн 6.2.3, 32.2.16, 34.1.2, 44.1.2,<br>-Валютын зохицуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйл, 10 дугаар зүйл<br>-Дээрх хууль тогтоомжтой нийцүүлэн гаргасан холбогдох байгууллагын шийдвэр, бусад баримт бичиг                                     |
| Нэмэлт шаардлага: Тухайн гүйцэтгэх ажлын хүрээнд шаардлагатай нэмэлт ажил гүйцэтгэх. |  |                          |   |   |   |

ОРОЛЦОХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

[2023.....]

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ**

Танай [он, сар, өдөр]-ийн шинжээч сонгон шалгаруулах зар/урилга болон хамтран ажиллах албан хүсэлтийг үндэслэн өөрсдийн оролцох хүсэлтийн дагуу [.....дүгнэлт гаргах ажилд ..... тоогоор үсгээр төгрөгөөр гүйцэтгэх саналыг үүгээр хүргүүлж байна. /төсвийн тооцооллыг хавсаргав./

Гэрээний хэлэлцээрийн үр дүнд өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд энэхүү санал өөрчлөгдөхгүй.

Ирсэн аливаа саналаас та татгалзах эрхтэй болохыг бид хүлээн зөвшөөрч байна.

Хүндэтгэсэн

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ЗАХИРАЛ ..... /...../

ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН АХЛАГЧ ..... /...../

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг: .....

холбоо барих утас: .....

## ОРОЛЦОГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

## 3.1. Ерөнхий танилцуулга

.....  
 .....  
 (Оролцогч хуулийн этгээд нь ерөнхий танилцуулгад холбогдох үйл ажиллагаа явуулах бүртгэлийн болон эрхийн гэрчилгээг хавсаргаж ирүүлнэ)

## 3.2. Хуулийн этгээд/баг/хувь хүний чадварыг харуулж чадах сүүлийн 3 жилд үзүүлсэн ижил, төстэй үйлчилгээний мэдээлэл

Доорх хүснэгтийн дагуу хуулийн этгээд нь дангаараа болон хамтарч албан ёсоор үзүүлсэн үйлчилгээ бүрийн тухай мэдээлнэ үү. Нотлох баримтыг хавсарган ирүүлэх шаардлагатай.

|   |                      |  |
|---|----------------------|--|
| Гүйцэтгэсэн ажлын нэр:  |                      | Улсын нэр:   |
| Байршил:  |                      | Танай байгууллагаас ажилласан мэргэжилтэн (чиглэл):              |
| Захиалагчийн нэр:   |                      | Ажилтны тоо:   |
| Хаяг:   |                      | Гүйцэтгэсэн ажлын хугацаа, хүн-сарын тоо:                        |
| Эхэлсэн он сар өдөр:  | Дууссан он сар өдөр: | Ажлын өртөг (сая төгрөгөөр) ойролцоогоор:                        |
| Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн нэр (хэрэв байвал):   |                      | Түншлэн ажилласан гүйцэтгэгчийн ажилтнуудын ажилласан сарын тоо: |
| Голлох мэргэжилтэн: (Төслийн удирдагч/зохицуулагч, төслийн ахлагч)-ийн гүйцэтгэсэн ажил, үүргүүд: |                      |  |
| Төслийн талаарх товч танилцуулга:   |                      |  |
| Төслийн хүрээнд танай ажилтны гүйцэтгэсэн үндсэн үйлчилгээний талаарх танилцуулга:                |                      |  |

Хуулийн этгээд/баг/хувь хүний нэр: \_\_\_\_\_

## САНАЛ БОЛГОЖ БУЙ МЭРГЭЖИЛТНИЙ НАМТАР(CV)-ЫН ЖИШИГ МАЯГТ

Санал болгож буй албан тушаал: \_\_\_\_\_

Байгууллагын нэр: \_\_\_\_\_

Мэргэжилтний нэр: \_\_\_\_\_

Мэргэжил: \_\_\_\_\_

Төрсөн он, сар, өдөр: \_\_\_\_\_

Тухайн байгууллагад ажилласан жил: \_\_\_\_\_ Иргэншил: \_\_\_\_\_

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: \_\_\_\_\_

Хариуцах ажил: \_\_\_\_\_

Ур чадварын:

*[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршлыг зааж харуулах.*

Боловсрол:

*[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.*

*[Мөн нотлох баримтыг материалд хавсарган ирүүлэх шаардлагатай ]*

Ажилласан туршлага:

*[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]*

Хэлний мэдлэг:

*[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшнийг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]*

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: \_\_\_\_\_ Огноо: \_\_\_\_\_



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХЭД ШААРДАГДАХ АЖЛЫН БАЙР,  
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ<sup>1</sup>

| № | Нэр             | Хаяг, байршил | Хүчин чадал |
|---|-----------------|---------------|-------------|
| 1 | Ажлын байр      |               |             |
| 2 | Тоног төхөөрөмж |               |             |
|   |                 |               |             |

БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН БОЛОН АЖЛЫН ХУВААРИЛАЛТ

| № | Нэр | Албан тушаал | Хариуцах ажил |
|---|-----|--------------|---------------|
|   |     |              |               |
|   |     |              |               |
|   |     |              |               |
|   |     |              |               |
|   |     |              |               |

АЖЛЫН ХӨТӨЛБӨР БОЛОН АРГАЧЛАЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

- *Ажлын хөтөлбөрийг ажлын даалгавартай уялдуулан цаг хугацаагаар хуваарилан дэлгэрэнгүй байдлаар хүснэгтээр гаргаж ирүүлэх.*
- *Ажил гүйцэтгэх аргачлалыг ирүүлэх.*

Баталгаажуулах

<sup>1</sup> Ажлын байр, тоног төхөөрөмжийн зургийг хавсаргаж ирүүлнэ.